



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/193

Улаанбаатар хот

「Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын
газрын балансаас хөрөнгө
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 6,169,974 (зургаан сая нэг зуун жаран есөн мянга есөн зуун далан дөрөв) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Баянзүрх дүүргийн (Нийтлэг үйлчилгээний газар-1) газрын балансад шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газар (И.Баттөгс)-т зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж авахыг Баянзүрх дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар-1 (Д.Өлзийдэмбэрэл)-д үүрэг болгосугай.

3.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Баянзүрх дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар-1 (Д.Өлзийдэмбэрэл), Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газар (И.Баттөгс)-т үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА  М.БАЯРАА



115050000585

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2021 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн А/193 дугаар тушаалын хавсралт



Байгууллагын нэр: Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газар

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Шилжүүлэн авах байгууллага	
	Тавилга, эд хогшил										
1	Шкаф ЗД		10	ширхэг	1	6,169,974.00	6,169,974.00	6,169,674.00		Баянзүрх дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар-1	
	Нийт балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн дүн						6,169,974.00	6,169,674.00		-	